



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар A/125

Арвайхээр сум

### Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн A/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 2 нэгж талбарыг эзэмшигчдийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Газар эзэмших эрх шинээр олгох тухай” A/401 дүгээр захирамжийн хавсралтын Б.Пүрэвдоржтой холбогдох хэсэг, 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” A/180 дугаар захирамжийн хавсралтын Б.Мөнхбаатартай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН



8224 11 0264

Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар  
сарын 11-ны өдрийн 11:15 дугаар  
захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД  
ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м <sup>2</sup> ) газраас	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м <sup>2</sup> ) газрыг	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмшигчийн хугацаа
1	Б.Пүрэвдорж	ЙИ86012315	Амины орон сууц	263	О.Дэмчигдорж Б.Отгонбаяр	ЙЮ91100538 ЙЮ92102411	Амины орон сууц	263	13 дугаар баг, Дөл-1 гудамж, 105 тоот	28 жил
2	Б.Мөнхбаатар	ЙЮ94072632	Гэр, сууцны хашааны газар	407	Ч.Өлзийсайхан	ЙЖ71012219	Гэр, сууцны хашааны газар	407	5 дугаар баг, Худалдаа-4 гудамж, 413 тоот	33 жил